



МОНГОЛ УЛСЫН  
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/БЧ

Улаанбаатар хот

Аймаг, нийслэл, хот хооронд шуудангийн  
илгээмж хүргэх хуваарь, чиглэлийг батлах  
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шуудангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2023-2024 оны шуудангийн илгээмж хүргэх хуваарь, чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Шуудангийн илгээмж хүргэх хуваарь, чиглэлийг шуудангийн илгээмж тээвэрлэгч этгээдийн үйл ажиллагаатай уялдуулан шууданг тасралтгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор өөрсдийн хуваарьт тухай бүр өөрчлөлт оруулж болохыг дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд зөвшөөрсүгэй.

3.Шуудангийн илгээмж хүргэх хуваарь, чиглэлийн мэдээллийг улирал тутамд шуудангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэхийг дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд даалгасугай.

4.Дотоодын шуудангийн илгээмж хуваарийн дагуу хүргэгдэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хороо (Г.Чинзориг)-нд үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар, Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт тус тус даалгасугай.

САЙД



Н.УЧРАЛ



